



127 Page



128 Page



129 Page

# Самсон

-Samson-

**Тайлбарлагч** Израильчууд их гэм нүгэл үйлджээ. Үүнийг харсан Бурхан Филист хүмүүсээр дамжуулан Израильчуудыг зовоон шийтгэв. Нэгэн өдөр Маноа гэдэг нэгэн хүүхэдгүй хүний гэрт Эзэний тэнгэр элч иржээ.

**Тэнгэр элч** Чи удахгүй хүүтэй болох болно. Тэр хүүгийн үсийг огт тайрч болохгүй. Тэр хүү том болоод Израилийг аюулаас аврах болно.

**Тайлбарлагч** Маноа болон түүний эхнэр ихэд баярлав. Удалгүй Маноагийн эхнэр жирэмсэлж, хүү төрүүлэв. Тэд хүүгээ Самсон гэж нэрлэв. Самсон маш хүчтэй нэгэн байжээ. Бурхан Самсонтой хамт байж түүнийг маш ихээр ерөөв. Самсоны үс маш урт ургасан ч эцэг эх нь тэнгэр элчийн хэлсний дагуу үсийг нь огт тайрсангүй.

**Тайлбарлагч** Самсон өсөж том болоод эрийн цээнд хүрчээ. Тэр маш хүчтэй учраас Филлистчүүд түүнээс айж байв. Тэрээр арслан, баавгайнаас ч айхгүйгээр амыг нь зад татдаг байжээ. Нэгэн удаа гурван зуун үнэгийг сүүлээр нь холбож гал асаагаад Филлистчүүдийн тариан талбай уруу оруулсанаар тэр хавийг бүхэлд нь шатааж орхижээ.

**Тайлбарлагч** Самсоноос болж Филлистчүүд өөрсдийг нь зовоох вий гэж бодсон Израильчууд түүнийг гинжээр хүлээд Филлистчүүдэд барьж өгсөн боловч бурхан самсонд хүчийг өгсөн болохоор тэр хүлээсийг дор нь тас татчихжээ.

**Самсон** Энд илжигний эрүүний яс байх чинь!

**Тайлбарлагч** Самсон илжигний эрүүний ясаар мянган Филист цэргийг хөнөөжээ.

**Тайлбарлагч** Гэтэл Самсон үнэхээр үзэсгэлэнтэй нэгэн Филист эмэгтэйд дурлажээ. Түүний нэрийг Делила гэдэг байв. Гэвч Делила мөнгөнд шуналтай эмэгтэй байж. Нэгэн өдөр Самсоныг унтаж байхад нь Филистийн ноёдууд Делилатай уулзахаар ирэв.

**Ноёд** Делила, чи Самсоны хүч чадлын нууцыг олж мэдээд бидэнд хэлвэл чамайг баян болгож өгье.

**Тайлбарлагч** Тэр өдрөөс хойш Делила Самсоны хүч чадал хаана байдгийг мэдэхийн тулд түүнийг ятгаж эхлэв гэнэ.

**Делила** Самсон! Хүч чинь хаана байдгийг надад хэлээч?

**Тайлбарлагч** Гэвч Самсон Филист эмэгтэйд хэлэхгүй байв.

**Самсон** Намайг долоон ширхэг шинэхэн нумын хөвчөөр хүлэх юм бол би дорой болно.

**Тайлбарлагч** Үүнийг сонсоод Делила, Самсоныг унтахыг хүлээж байгаад долоон ширхэг нумын хөвчөөр түүнийг хүлж орхив.



130 Page

**Тайлбарлагч** Тэгээд чангаар хашхирчээ.  
**Делила** Самсон! Яадаг билээ! Филистийн цэргүүд чамайг барихаар ирж байна.

**Тайлбарлагч** Үүнийг сонсоод Самсон нойрноосоо сэрж, хүлээсээ зад татжээ. Делила өдөр бүр түүнээс хүч чадал хаана байдгийг мэдэхээр түүнийг ятгаж байлаа.

**Самсон** Огт хэрэглэж байгаагүй, цоо шинэ олсоор намайг хүлвэл миний хүч алга болно.

**Самсон** Миний толгойн туг үсийг нэхэж, нэхмэл зүүгээр сүлбэвэл би дорой болж жирийн хүний адил болно.

**Тайлбарлагч** Мөнгөнөөс болж ухаанаа алдсан Делила, Самсоны хэлсэнээр бүгдийг хийсэн боловч хүч нь алга болохгүй байлаа.

**Тайлбарлагч** Самсон өөрийг нь хуурсаныг мэдсэн Делилагийн уур нь хүрчээ.  
**Делила** Самсон аа Чи үнэхээр худалч хүн юмаа. Надад хайртай гэж яаж надад хэлж чадна вэ? Чиний хүч чадал хаана байдгийг надад хурдан хэлж өг!



131 Page

**Тайлбарлагч** Делила Самсоныг өдөр бүр үгээр дарамталж байсанд түүний сэтгэл санаа мохож бүгдийг нь хэлжээ.

**Самсон** Делила, би бол Бурханы хүн. Миний хүч чадал миний үсэнд байдаг. Үсээ тайрвал би хүчээ алдана.

**Тайлбарлагч** Үүнийг сонссон Делила Самсоныг унтсан хойгуур үсийг нь тайрчихжээ. Ингээд Самсон хүчгүй болов.



132 Page

**Тайлбарлагч** Филистчүүд Самсоныг бариад гинжээр хүлж, шоронд хийв. Тэрээр гинжийг таслах гэсэн боловч ямар ч хүчгүй болсон учраас чадахгүй байлаа. Бурхан аль хэдийн түүнээс холджээ. Филистчүүд түүний хоёр нүдийг сохлон, шоронд тээрмийн чулууг эргүүлдэг ажил хийлгэх болжээ. Харин удалгүй Самсоны үс нь ургаж эхлэв. Самсоныг барьсаны төлөө филистчүүд найр хийхээр цугларсан байлаа.


**Эрэгтэй1** Биднийг зовоож байсан Самсоныг барьчихлаа. Тэр сохорсон. Одоо шоронд тээрэм эргүүлж байгаа.

**Эрэгтэй2** Үнэн гэж үү? Сайн хэрэг болжээ! Хурдхан шиг найр хийцгээе.

**Тайлбарлагч** Филистчүүд бүгд том ордонд цуглан Самсоныг шоолж байв.

**Эрэгтэй1** Самсон, биднийг нэг хөгжөө дөө! Биднийг хурдан инээлгэх юм хийгээдэх!

**Тайлбарлагч** Хүмүүс сохор Самсоны хөөрхийлөлтэй царайг харан инээцгээж байв.



133 Page

**Тайлбарлагч** Самсон хажуудаа байсан хүүгээс нэгэн зүйлийг хүсэв.

**Самсон** Намайг энэ барилгын тулгуур багана уруу хүргэж өгөөч!

**Тайлбарлагч** Самсон тэр барилгын тулгуур хоёр багануудын хооронд гараараа тулж зогсоод Бурханд хандан залбирав.

**Самсон** Бурхан минь! Энэ удаа л надад хүчийг өгөөч. Намайг тамласан хүмүүсээс өшөөгөө авахыг минь зөвшөөрөөч. Би энэ хүмүүстэй хамт үхсэн ч хамаагүй!



134 Page

**Тайлбарлагч** Самсон залбираад хамаг хүчээрээ хоёр баганыг өргөв.

**Самсон** Би Филистчүүдтэй хамт үхэх болно!

**Тайлбарлагч** Түс, тас ! Хоромхон зуур тэр барилга нурж, дотор нь байсан бүх хүн үхэв. Самсоны үхэхдээ хөнөөсөн хүмүүс нь түүний амьд байхдаа хөнөөсөн хүмүүсээс ч хэд дахин олон болов. Ийнхүү Самсон Филистчүүдтэй хамт үхжээ.